

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
4 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-8
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	9-54
	1.Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын нэмэлт, санхүүжилтийн хэлэлцээр /Монгол Улсад КОВИД-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл/-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	10-28
	2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай	28-33
	3.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай	34-40
	4.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний найдвартай аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын талаар/	40-51
	5.Хүний эрх, хамгаалагч эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	52-53
	6. Хууль эцэслэн батлах	53-54

Хураангуй тэмдэглэл

Зургаа.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т “Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасны дагуу хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалтыг МуParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: 1.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 23
Бүгд: 54
71.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 14
Бүгд: 54
74.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 11

Бүгд: 54

79.6 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Дагалдан гарсан:

1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 12

Бүгд: 54

77.6 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 14

Бүгд: 54

74.1 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 15

Бүгд: 54

74.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:34/

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, мөн хэлтсийн ахлах референт Ч.Тунгалаг, шинжээч У.Энхжин нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 07 минут үргэлжилж, 75 гишүүнээс 54 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Тав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатараас 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх, хамгаалагч эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, ирцийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрх, хамгаалагч эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг оролцуулаарай. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Аюурсайхан гишүүнээр тасаллаа. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн асуулт асууна. Цахимаар асуулт байна уу? Алга байна. Цахим асуулт тасаллаа.

Т.Аюурсайхан: Хүний эрх хамгаалагчийн тухай хууль шинэ хууль баталсан байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд үүнтэй холбогдуулаад нэмэлт, өөрчлөлт оруулаад ингээд эцсийн хэлэлцүүлгийг нь хийж байна. Дахин сануулахад бол Хүний эрхийн Үндэсний Комиссынхон ажлаа сайжруулах хэрэгтэй. Энэ чинь одоо удаан жил иймэрхүү байдлаар явлаа. Тэгээд тодорхой өөрчлөлт шинэчлэлт гаргахын тулд сонгон шалгаруулж нэр бүхий хүмүүсээс ажилд нь томилоод удаагүй байгаа. Тэгээд алхам тутамд хүний эрх зөрчигдөж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын тайланг Улсын Их Хурал хүлээж авсан байгаа. Удахгүй хэлэлцэнэ.

Өнөөдөр даргын дэргэдэх зөвлөл дээр Улсын Их Хурлын даргаас бас санал гаргаж Одонтуяа дэд дарга бас саналаа дэвшүүлж, Занданшатар дарга тодорхой чиглэл өгөөд, ирэх долоо хоногт Хүний эрхийн дэд хороог хуралдуулахаар болж байна. Энхийн цагт цэргийн албан хаагчийн амь нас одоо хохирно гэж байж болшгүй зүйл. Бид нар энийг удаа дараа хэлж байгаа, удаа дараа хэлж сануулж байгаа. Энэ бол дэндүү харамсалтай ийм явдал болж байна. Тэгээд энэ дээр бас тодорхой үйл ажиллагаа явуулж дүгнэлт гаргаж, тэр цэргийн анги нэгтгэлүүд дээр одоо ажиллаж Хүний эрхийн Үндэсний Комиссынхон тодорхой нөхцөл байдлыг судалж тогтоож ингэж явахгүй бол одоо тохиолдол болгон дээр дугуй уугаад байдаг. Ер нь хүний эрх хаана зөрчигдөж байна? Үндсэн хуульд заасан нэгдүгээр эрх нь мөн шүү дээ, хүний эрхийн. Хүн амьд явах эрхтэй. Энэнд нь ноцтой хэрцгийгээр халдаж байхад нь дуугүй байж байдаг. Тэгээд хараад л одоо ингээд л ийм байдлаар Хүний эрхийн Үндэсний Комисс бол цаашдаа ажиллахгүй ээ. Тэгээд хууль тогтоомжийг нь одоо сайжруулж байна.

Г.Занданшатар: Санал юм даа. Үг хэллээ.

Одоо санал хураалт явуулна. Үдээс хойших туршилтын санал хураалт, бүртгэлийн санал хураалт явуулаагүй байгаа. Улсын Их Хурлын гишүүдийг цахим санал хураалтдаа бэлтгэж, онцгой нөхцөлд цахимаар хуралдаж байгаа учраас MyParliament программыг ашиглаж саналаа өгөх бүртгэлд орно уу гэж бүртгэлийн санал хураалт. Туршилтын санал хураалт явуулна. Түрүүн бүртгэл хийсэн.

Бүртгэлд орохгүй байгаа Анадбазар Аубакир, Баатарбилэг, Баделхан, Бат-Амгалан, Батлут, Батсуурь, Баттөмөр, Баярсайхан, Бейсен, Болорчулуун, Жамбалын Ганбаатар, Н.Ганибал, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Гонгорын Дамдинням сая байсан, Тогмидын Доржханд, Болдын Жавхлан, Цэндийн Мөнх-Оргил, Лхагвын Мөнхбаатар, Жамъянгийн Мөнхбат, Нанзадын Наранбаатар, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Даваажанцангийн Сарангэрэл, Батсүхийн Саранчимэг, Цэдэвийн Сэргэлэн, Цэвэгдоржийн Туваан, Чинбатын Ундрам, Одонгийн Цогтгэрэл, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Содномын Чинзориг, Баттогтохын Чойжилсүрэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Баттөмөрийн

Энхбаяр, Нямаагийн Энхболд, Дамдинсүрэнгийн Өнөрболор нар бүртгэлд орохгүй байна. Энэ улсуудад туслахууд нь хэлээрэй. Энэ улсууд бүртгэлдээ ор. Бүртгэлд орохгүй бол ирцнээс хасагд. Тасалсанд тооц.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. Энийг бас санал хураалт хийхгүй шилжүүлэх ёстой юм. Одоо тэгээд хууль эцэслэн батлах санал хураалтыг Улсын Их Хурлын дарга, мэдээлнэ. Тав дахь өдөр эцэслэн баталжуулна гэж заасан байгаа.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүдийг чөлөөлөх, томилох тухай тогтоолыг баталсны дараа эцсийн хэлэлцүүлэг явуулна. 39-өөс дээш, нийт гишүүдийн олонхоор хууль эцэслэн батлах тул гишүүд цахим санал хураалтын тоног төхөөрөмжид орж бүртгэгдэнэ үү.

Ингээд Байнгын хороонд шилжүүлчихсэн тул одоо Улсын Их Хурлын тогтоолоо баталъя. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд санал хураалт явуулсан. Санал хураалтаар Энхтайваны Энхжаргал, Лхагважавын Төр-Од нар дэмжигдэж, бусад нь нэр дэвшээгүй учраас тогтоолын төсөлд өөрчлөлт орсон. Тогтоолын эцсийн найруулгыг уншиж танилцуулъя.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Энэбишийн Оюунтэгш, Намгарын Алгаа нарыг чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн тул Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энхтайваны Энхжаргал, Лхагважавын Төр-Од нарыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр томилсугай.

3.Энэ тогтоолыг 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр санал гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

Одоо санал хураалт явуулна. Эцэслэн батлах санал хураалт явуулна, тийм ээ. Ахиад бүртгэлийн санал хураалт явъя. Хууль эцэслэн батлах санал хураалт явуулна. Энэ гишүүдийн тоног төхөөрөмж MyParliament программын гацалтыг дахиж нэг удаа шалгаад, тэгээд санал хураалт явуулна. Шалгалтын санал хураалт. Дамдины Цогтбаатар, Мөнхбат хоёр эсрэг гарсан байна. Дэмжсэн тооцоорой гэсэн юм байна. Тэгэхдээ 39 санал дэмжигдсэн.

Ингээд санал хураалтад 54 гишүүн оролцож, 39 гишүүн дэмжиж нийт гишүүдийн олонхын саналаар хууль эцэслэн батлагдлаа.